

**ХӨТӨЛБӨРИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ  
ХУРЛЫН ТОВЧ ТЭМДЭГЛЭЛ**

2023 оны 03 дугаар сарын 31

№04

Улаанбаатар хот

Хөтөлбөрийн ерөнхий хорооны хурал 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдөр цахимаар (Microsoft teams) 10:00 цагаас 94.12 хувийн ирцтэй эхэлж, ХЕХ-ны дарга Н.Эрдэнэхүү удирдан явуулав.

Хуралд: Дарга Н.Эрдэнэхүү, нарийн бичгийн дарга М.Эрдэнэтуяа, гишүүн Д.Оюунцэцэг, М.Оюунчимэг, Б.Оюунтунгалаг, Л.Амартүвшин, Б.Батдэмбэрэл, Я.Батцэцэг, П.Ууганбаяр, Ш.Цоож, Р.Мядагмаа, Г.Батцэцэг, Ч.Улам-Оргил, Д.Ариунболор, Д.Дулмаа, Г.Ариунтөгс нар оролцов.

**Хэлэлцсэн асуудал:**

1. Дархан-Уул аймаг дахь технологийн сургуульд бусад бүрэлдэхүүн сургуультай хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх тухай (1+3)
  - ДаТС-ийн Сургалт, чанарын албаны дарга У.Эрдэнэболд
2. ШУТИС-ийн харьяа Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуульд ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуультай хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх тухай (1+3)
  - Сургалтын албаны дарга Д.Ичинхорлоо
3. ШУТИС-ийн харьяа Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуульд ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуультай хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх тухай (1+3)
  - Сургалтын албаны дарга Д.Болор-Эрдэнэ
4. Бусад асуудал

**ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:**

№	Хэлэлцүүлсэн асуудал	Санал, зөвлөмж	ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:
1.	Дархан-Уул аймаг дахь технологийн сургуульд бусад бүрэлдэхүүн сургуультай хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх тухай (1+3)	<p>Үндсэн хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн баталсан сургалтын төлөвлөгөөний дагуу сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах;</p> <p>Орон нутгийн босго оноо (410) давсан элсэгч орж ирэх тул ДаТС нь цаашид оюутан болгон төлөвшүүлэх үүднээс хувь хүний хөгжлийн тодорхой хөтөлбөр хэрэгжүүлэн, модуль сургалтуудыг зохион байгуулах, суралцах арга барилд сургах;</p> <p>Шаардлагатай тохиолдолд үндсэн сургуулийн багш орон нутагт хичээл заах нөхцөлийг хамтын ажиллагааны гэрээнд нарийн тусгаж өгөх;</p> <p>ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуультай холбогдож, хөтөлбөр хариуцсан үндсэн нэгж, ХДХ-ны саналыг тусган, харилцаа холбоогоо уялдуулах, өөрийн сургуулийн багш нарыг мэдээллээр тогтмол хангаж, багшийг чадавхижуулах сургалтуудыг хамтран зохион байгуулж ажиллах;</p> <p>Тухайн хөтөлбөрөөр элсэгчдийн хувьд түвшин тогтоох шалгалт (оролт, гаралт) зохион байгуулж үнэлгээ хийх;</p> <p>ДаТС ҮТС-тай хамтран хэрэгжүүлэх "Арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн технологи" хөтөлбөрийг дахин тодруулж элсэлт зарлах эсэхийг тодорхой болгох;</p> <p>Хамтарсан (1+3) хөтөлбөрөөр элссэн оюутныг ДаТС-д эхний жил суралцаад нэмэлт шалгуургүйгээр үндсэн хөтөлбөр хэрэгжүүлж буй сургуульд шилжүүлэх;</p> <p>Элсэлтийн маркетинг дээрээ анхаарч орон нутгийн давуу талаа харуулсан байдлаар ажиллах;</p>	<p>Төрөөс баримтлах бодлогын хүрээнд орон нутгийн элсэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлж байгаа, багшлах боловсон хүчин хангагдсан, сургалтын орчин, оюутны байрны хүртээмжтэй байдал, Улаанбаатар хотод элсэх элсэлтийн босго оноо хангаагүй тухайн хөтөлбөрөөр цаашид суралцах хүсэлтэй элсэгчдийг дэмжих зэрэг үндэслэлийг харгалзан бусад бүрэлдэхүүн сургуультай бакалаврын 6 хөтөлбөрөөр хамтарсан (1+3) хөтөлбөр хэрэгжүүлэх саналыг (100%) дэмжлээ.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. БАС - Авто замын инженерчлэл (073210)</li> <li>2. МехТС - Механик инженерчлэл (071501)</li> <li>3. МХТС - Мэдээллийн систем (061303)</li> <li>4. МХТС - Кибер аюулгүй байдал (061202)</li> <li>5. ҮТС - Арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн технологи (072303)</li> <li>6. ЭХС - Цахилгаан хангамж (071310)</li> </ol>
2.	ШУТИС-ийн харьяа Өмнөговь аймаг дахь	Үндсэн хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн баталсан сургалтын	Төрөөс бодлогоор дэмжиж байгаа, Өмнөговь аймагт

	<p>Технологийн дээд сургуульд ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуультай хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх тухай (1+3)</p>	<p>төлөвлөгөөний дагуу сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах;</p> <p>Шинээр хөтөлбөр хэрэгжүүлж байгаа тул ачаалал нэмэгдэж, багшлах боловсон хүчний асуудал хөндөгдөнө. Улаанбаатар хотоос очиж буй багш нарын орон сууцны асуудал, сургалтын орчин нөхцөлийг сайжруулахад анхаарах;</p> <p>ШУТИС-ийн үндсэн хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлж байгаа тул ШУТИС-ийн дүрэм журмын хүрээнд үйл ажиллагааг зохион байгуулж, баримт бичгийг албажуулах;</p> <p>ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуультай холбогдож, хөтөлбөр хариуцсан үндсэн нэгж, ХДХ-той хамтран ажиллаж, өөрийн сургуулийн үйл ажиллагааг тогтворжуулах;</p> <p>Сургалтын чанарыг нэгдүгээрт тавьж ажиллах, дээд боловсролын суурь хичээл нь суралцагчийн үндсэн хөтөлбөрөөр эзэмших ур чадварын суурь байдаг гэдгийг анхаарах;</p> <p>Үндсэн багшийн асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх;</p> <p>ШУТИС-ийн харьяа сургууль тул Сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөлд (1+3) хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх гэдгээр тусгуулах;</p> <p>Элсэлтийн үйл ажиллагаанд анхаарч, хяналтыг тооны санал ирүүлэх ба төвийн сургуулийн саналтай уялдуулж тогтоох;</p>	<p>ойрын 5 жилд хэрэгжих, томоохон төслийн хүрээнд хийгдэх бүтээн байгуулалтад шаардлагатай мэргэжилтнийг бэлтгэх, орон нутгаас тухай сургуулийн сургалтын орчинг сайжруулахад тодорхой ажлууд хийгдэхээр төлөвлөгдсөн, орон нутгийн элсэгчдэд төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх, Улаанбаатар хотод элсэх элсэлтийн босго оноо хангаагүй тухайн хөтөлбөрөөр цаашид суралцах хүсэлтэй элсэгчдийг дэмжих зэрэг үндэслэлийг харгалзан ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуультай бакалаврын 3 хөтөлбөрөөр хамтарсан (1+3) хөтөлбөр хэрэгжүүлэх саналыг (75%) дэмжлээ.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. БАС - Барилгын инженерчлэл (073204)</li> <li>2. МехТС - Үйлдвэрлэлийн автоматжуулалт (071402)</li> <li>3. МехТС - Авто инженерчлэл (071601)</li> </ol> <p>Дараагийн шатанд хэлэлцүүлэн, дэмжигдсэн тохиолдолд БШУЯ-аас тавигдах шаардлагын дагуу баримтыг бүрдүүлж, хамтарсан хөтөлбөр (1+3)-өөр сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэх;</p>
3.	<p>ШУТИС-ийн харьяа Эрдэнэт цогцолбор дээд сургуульд ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуультай хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх тухай (1+3)</p>	<p>Үндсэн хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн баталсан сургалтын төлөвлөгөөний дагуу сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах;</p> <p>ШУТИС-ийн үндсэн хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлж байгаа тул ШУТИС-ийн дүрэм журмын хүрээнд үйл ажиллагааг зохион байгуулж, баримт бичгийг албажуулах;</p>	<p>Төрөөс баримтлах бодлогын хүрээнд орон нутгийн элсэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлж байгаа, багшийг чадавхижуулах, сургалтын орчин, оюутны байрны хүртээмжтэй байдал, Улаанбаатар хотод элсэх элсэлтийн босго оноо хангаагүй тухайн хөтөлбөрөөр цаашид суралцах хүсэлтэй элсэгчдийг дэмжих зэрэг үндэслэлийг харгалзан бусад</p>

		<p>Элсэлтийн үйл ажиллагааны зохион байгууллын санал ирүүлэх, хяналтын тоог төвийн сургуулийн саналтай уялдуулж тогтоох;</p> <p>Өмнө хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлсэн талаар дэлгэрэнгүй мэдээлэл гаргаж БАС-д хүргүүлэх;</p> <p>ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль, хөтөлбөр хариуцсан үндсэн нэгж, ХДХ-ны саналыг тусган ажиллах;</p> <p>ШУТИС-ийн харьяа сургууль тул Сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөлд (1+3) хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх гэдгээр тусгуулах;</p>	<p>бүрэлдэхүүн сургуультай 4 хөтөлбөрөөр 1+3 хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх саналыг (100%) дэмжлээ.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. БАС - Хаягдал боловсруулах технологи (071205)</li> <li>2. БАС - Барилгын инженерчлэл (073204)</li> <li>3. МехТС - Механик инженерчлэл (071501)</li> <li>4. ЭХС - Цахилгаан хангамж (071310)</li> </ol> <p>Дараагийн шатанд хэлэлцүүлэн, дэмжигдсэн тохиолдолд БШУЯ-аас тавигдах шаардлагын дагуу баримтыг бүрдүүлж, хамтарсан хөтөлбөр (1+3)-өөр сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэх;</p>
4.	Бусад асуудал	<p>Хөтөлбөрийн ерөнхий хорооны төлөвлөгөөний дагуу хийж буй ажлын мэдээлэл;</p> <p>Ахисан түвшний хөтөлбөрийн албанаас Хөтөлбөрийн ерөнхий хороонд гишүүдэд өөрчлөлт оруулах санал;</p>	<p>Хөтөлбөрийн ерөнхий хорооны ажлын төлөвлөгөөний дагуу төлөвлөсөн ажилд гишүүдийн оролцоог сайжруулан төлөвлөгөөнд тусгасан хугацаандаа ажлын гүйцэтгэлээ гаргаж явах;</p> <p>Хөтөлбөрийн хорооны журамд гишүүдийн тоо заасан тул журамд өөрчлөлт оруулж шийдвэрлэх;</p>

Танилцсан:



Н.Эрдэнэхүү  
/ХЕХ-ны дарга/

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:



Г.Ариунтөгс  
/ХЕХ-ны гишүүн/